

“ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024.03.28

Улаанбаатар хот

Хурал 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 10:00 цагт “Хөнгөн бетон” ХК-ийн хурлын өрөөнд 10:00-10:15 цагт хуралдав.

Тооллогын комиссын дарга Г.Ганзориг хувьцаа эзэмшигчдийн ирцийг танилцуулж саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийг танилцуулав. Үүнд:
“Хөнгөн бетон” ХК-ийн зарласан бөгөөд гаргасан энгийн хувьцааны 179,373 ширхэг хувьцаа ба ирсэн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаа 177,154 ширхэг байгаа ба 98.76%-ийн ирцтэй байгаа тул хүчин төгөлдөр гэж үзэж хурлыг эхлүүлэв.

1. Б.Наранзул – 130,958 ширхэг хувьцаа
2. Б.Наранцацралт – 30,244 ширхэг хувьцаа
3. “Минжит булган гол” ХХК - 14,918 ширхэг хувьцаа
4. Т.Баярхүү /өв залгамжлагч: Б.Наранцацралт, Б.Наранзул / - 1,034 ширхэг хувьцаа

Тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав.

Хурлын дарга Б.Наранзул хурлыг нээж үг хэлэв. “Хөнгөн бетон” ХК-ийн ээлжит хурлыг нээснийг мэдэгдье. Эхний ээлжинд хурлын дэгийг танилцуулъя.

Хурлаар хэлэлцэх асуудал тус бүрийг нь хэлэлцээд асуудал тус бүрээр нь саналыг аваад шийдвэрлээд явах саналтай байна. Үүнтэй санал нэг байна уу?

Шийдвэрлэсэн нь: Өөр санал гаргаагүй тул хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 %-ийн саналаар хурлын дэгийг батлав.

Б.Наранзул: Тооллогын комиссын дүнг авъя.

Асуудал 1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, дүгнэлтийг хэлэлцэж батлах.

Хурлын дарга Б.Наранзул: 2023 оны компанийн үйл ажиллагааны тайланг уншиж танилцуулав.

Хурлын дарга Б.Наранзул: Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтийг батлах уу?

Хурлын дарга Б.Наранзул: 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын №01 тоот “Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах” тогтоолын төслийг хамтад нь танилцуулав.

Шийдвэрлэсэн нь: Өөр санал гараагүй тул хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлав.

Асуудал 2. Ногдол ашгийн тухай

Хурлын дарга Б.Наранзул: ХАС банкны хамтарсан зээлээр аливаа өр зээлийг төлж барагдуулах хүртэл ногдол ашгийг хуваарилж төлөхгүй гэсэн зээлийн гэрээний үүрэг хүлээсэн учир ногдол ашиг хуваарилах боломжгүй угаасаа компани алдагдалтай ажиллаж байгаа.

Хурлын дарга Б.Наранзул: Цаашид ч ногдол ашиг хуваарилахгүй байх талаар саналаа хураая. Гэрээний дагуу үүргээ биелүүлэхийг зөвшөөрч байна уу?

Хурлын дарга Б.Наранзул: 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын №02 тоот “Компанийн 2023 оны ногдол ашгийн тухай” тогтоолын төслийг хамтад нь танилцуулав.

Шийдвэрлэсэн нь: Өөр санал гараагүй тул хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлав.

Асуудал 3. ТУЗ-ийн гишүүдийг сонгох

Хурлын дарга Б.Наранзул: Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүдийг нэр дэвшүүлсэн саналыг танилцуулж байна. Анкетыг танилцуулав. (Тараах материал өгсөн бөгөөд гишүүн тус бүрээр анкеттай нь танилцана уу)

а/ ТУЗ-ийн ердийн гишүүд:

1. Баярхүү овогтой Наранзул
2. Баярхүү овогтой Наранцацралт
3. Баасанжав овогтой Мөнхцацралт
4. Баасанжав овогтой Алтанцэцэг
5. Гүндсамбуу овогтой Ганзориг
6. Аюурзана овогтой Чанцалдулам

б/ ТУЗ-ийн хараат бус гишүүд:

7. Шаравсамбуу овогтой Энхтөр
8. Дамдиндагва овогтой Эрдэнэбилэг
9. Өлзийбаяр овогтой Ариунболд

ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгоно, нэр дэвшсэн хүмүүст өгөх саналын тоогоо өгөөд саналаа хураая. Кумулятив аргын тухай саналын хуудасны доод хэсэгт тайлбар бичсэн байгаа. Тэр тайлбарыг уншиж зааврын дагуу саналаа өгөөрэй /саналын хуудсаа тараав/.

Хурлын дарга Б.Наранзул: Тооллогын комисс саналын хуудсыг нэгтгэсэн дүнгээ гаргаад саналын тоог танилцуулаарай.

Хурлын дарга Б.Наранцацралт: Төлөөлөн удирдах зөвлөл компани хүнд байдалд байгаа тул цалингүй байх саналтай байна.

Шийдвэрлэсэн нь: Өөр санал гараагүй тул хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлав.

Асуудал 4. Компанийн хэлбэрийг өөрчлөх

Хурлын дарга Б.Наранзул: 2020 оноос хойш компаний 98,76%-ийг нэгдмэл сонирхолтой этгээдүүд буюу манай гэр бүлд дийлэнхи хувьцаа төвлөрсөн байна. үлдсэн 1,24% хувьцаа эзэмшигчид огт ирдэггүй, оролцдоггүй тул компанийг Хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох саналтай байна.

Б.Наранцацралт: Нэгж хувьцааны үнийг яаж тогтоож 1,24%-ийн хувьцаа эзэмшигчдэд өгөх вэ?

Хурлын дарга Б.Наранзул: Компаний тухай хуулийн 55.8-д заасны дагуу нээлттэй хувьцаат компани тул хөрөнгийн биржийн сүүлийн 6 сарын арилжааны жигнэсэн дундаж ханшнаас доошгүй байхаар тооцно. Учир нь манай компаний өр төлбөр өөрийн хөрөнгөөс давсан бөгөөд бүх хөрөнгө барьцаанд байдаг. Тиймээс үнэлгээ хийлгэх боломжгүй.

Б.Наранцацралт: ХХК болгохыг зөвшөөрч байна. Сүүлийн 6 сарын дундаж ханш ойролцоогоор хэд байгаа вэ?

Хурлын дарга Б.Наранзул: 2020 оны 8 сараас хойш арилжаа хийгдээгүй. Манайх 3-р самбарт байдаг. Одоо санаж байгаагаар 250 төгрөгнөөс хэтрэхгүй нэгж үнээр тухай үед арилжаа хийж байсан. Тиймээс нэгж үнийг 300 төгрөг байхаар санал авъя.

Шийдвэрлэсэн нь: Өөр санал гараагүй тул хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлав.

Тооллогын комиссийн дарга Г.Ганзориг: Саналын хуудсыг нэгтгэн тооллоо. Үүнд:

- 1). “Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах” талаар саналын хуудсаар санал хураахад хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн байна.
- 2). “Компанийн 2023 оны ногдол ашгийн тухай” талаар саналын хуудсаар санал хураахад хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн байна.
- 3). ТУЗ-ийн ердийн ба хараат бус гишүүнд нэр дэвшигчдийг кумулятив аргаар санал хураахад

Ердийн гишүүд:

Д/д	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Кумулятив аргаар өгсөн саналын эрхийн тоо
1	Баярхүү овогтой Наранзул	177,154
2	Баярхүү овогтой Наранцацралт	177,154
3	Баасанжав овогтой Мөнхцацралт	177,154
4	Баасанжав овогтой Алтанцэцэг	177,154
5	Гүндсамбуу овогтой Ганзориг	177,154
6	Аюурзана овогтой Чанцалдулам	177,154


2	Баярхүү овогтой Наранцацралт	177,154
3	Баасанжав овогтой Мөнхцацралт	177,154
4	Баасанжав овогтой Алтанцэцэг	177,154
5	Гүндсамбуу овогтой Ганзориг	177,154
6	Аюурзана овогтой Чансалдулам	177,154

Хараат бус гишүүд:


Д/д	ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Кумулятив аргаар өгсөн саналын эрхийн тоо
1	Шаравсамбуу овогтой Энхтөр	177,154
2	Дамдиндагва овогтой Эрдэнэбилэг	177,154
3	Өлзийбаяр овогтой Ариунболд	177,154


4. Компанийн хэлбэрийг өөрчилж ХХК болох талаар хэлэлцэхэд хувьцаа эзэмшигчид 100% нь зөвшөөрсөн, 0 % нь түтгэлзсэн, 0 % нь татгалзсан байна.

Тооллогын комиссын дарга:

 F.Ганзориг

Тооллогын комиссын гишүүд:

 Б.Алтанцэцэг

 Б.Батбаяр